

ХРИСТЭЧ ИТГЭЛ ҮНЭМШИЛ СОРИЛЫН ХАРИУЛТ

1-р хичээл

Бурханы ном

(1) Ерөнхий илчлэл гэж юу вэ?

Бурхан бүтээлээрээ дамжуулан Өөрийнхөө тухай бидэнд харуулсныг Ерөнхий илчлэл гэдэг.

(2) Бурханы Онцгой илчлэл нь ямар хоёр хэлбэрээр өгөгдсөн бэ?

- Онгод оруулагдсан бичвэрүүд
- Түүний хүү Есүсээр

(3) Ерөнхий илчлэлийн хийж чадахгүй ямар гурван зүйлийг Онцгой илчлэл хийдэг вэ?

- Энэ нь Бурханыг тодорхойлдог.
- Энэ нь уналт болон нүглийг тайлбарладаг.
- Энэ нь Бурхантай эвлэрэх арга замыг харуулдаг.

(4) Библи өөрийнхөө талаар юу гэж хэлсэн бэ?

Энэ бол Бурханы Үг гэдгийг баталж байгаа юм.

(5) Библи бол Бурханы Үг гэдгийг бид мэдэх зургаан шалтгааныг жагсаана уу.

- Библийн мянга мянган баримтууд батлагдсан.
- Библийн ямар ч мэдэгдэл үгүйсгэгдэж байгаагүй.
- Библи өөртэйгөө зөрчилддөггүй.
- Сайнмэдээ нь түүний нөлөөгөөр нотлогддог.
- Бурханы Сүнс Библиэр дамжуулан ярьдаг.
- Бурхантай харилцах бидний харилцааг Библи чиглүүлдэг.

(6) Библи нь яагаад заах, зэмлэх, залруулах, зөвд чиглүүлэхэд тустай вэ? (2 Тимот 3:16).

Учир нь энэ нь Бурханы амьсгалснаар юм.

(7) Бичигчдийг алдаа гаргахаас хамгаалсан гэдгийг батлах онгодын талаар Библид юу гэж тодорхойлсон бэ?

Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс (2 Петр 1:21).

(8) Бурхан онгод оруулахдаа ашигласан дөрвөн аргыг жагсаана уу?

- Сонсогдохуйц дуу хоолой
- Зүүд
- Үзэгдэл
- Хэлж бичүүлэх

(9) Библи дэх Бурханы амьсгал гэж юуг хэлэх вэ?

Библи дэх Бурханы амьсгал нь Библийн үг бүр нь, бүхэлдээ Бурханы Үг гэсэн утгатай.

(10) Библи алдаа мадаггүй гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

- Бүтэлгүйтэх боломжгүй.
- Бид үүнд итгэж болно.
- Хэзээ ч биднийг төөрөгдүүлэхгүй.

(11) Библи зөв найдвартай гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Библи нь зөвхөн онол сургаалын үгсээрээ төдийгүй үүнд хэлэгдсэн үг бүрээрээ алдаа мадаггүй юм.

2-р хичээл

Бурханы шинж чанарууд

(1) Хүнийг тодорхойлох хамгийн чухал шинж юу вэ?

Бурханы талаарх түүний үзэл баримтлал.

(2) Бичвэрийн эхний хичээл юу вэ?

Бурхан бол оршин буй бүхний Бүтээгч юм.

(3) Дараах өгүүлбэрт тохирох Бурханы шинж чанаруудыг нэрлэнэ үү:

- Бурхан ямар харагддагийг бид дүрслэх боломжгүй: *сүнс*
- Бурхан үргэлж оршоор байгаа: *мөнхийн*
- Бурхан оюун ухаан, мэдрэмж, хүсэл эрмэлзэлтэй: *бодгаль*
- Бурхан үргэлж хэвээрээ: *өөрчлөгддөггүй*
- Бурхан сонгосон бүхнээ хийх чадвартай: *бүгдийг чаддаг*
- Бурхан бүхнийг хардаг: *хаа сайгүй оршдог*
- Бурхан Хүүгээ илгээсэн учраас бид өршөөлийг хүртсэн: *хайр*
- Бурхан мөн чанарынхаа хувьд гурван бодгалиар оршдог: *Гурвал*
- Бурхан туйлын төгс ёс суртахуунтай: *ариун*
- Бурхан хэнээр ч заалгахгүй: *бүхнийг мэддэг*
- Бурханы үйлс нь үргэлж зөв шударга юм: *зөв шударга*

3-р хичээл

Гурвал

(1) Орчлон ертөнц хэрхэн Бурханы мөн чанарыг дүрслэн харуулдаг вэ?

Орчлон ертөнц нь орон зай, цаг хугацаа ба матери гэсэн гурван хэсгийг агуулдаг.

(2) Гурвалын талаарх онол сургаалын суурь болсон гурван үндэслэл юу вэ?

1. Цорын ганц Бурхан байдаг.
2. Эцэг, Хүү, Ариун Сүнс бүгд Бурхан.
3. Гурвал нь ялгаатай бодгаль байдлаар бие биетэйгээ харилцдаг.

(3) Гурвал хоорондын харилцааны бүтэц юу вэ?

Эцэг бол тэргүүн, дараа нь Хүү, тэгээд Ариун Сүнс.

(4) Гэр бүл болон чуулганы бүтцийг Гурвалын бүтэцтэй хэрхэн харьцуулж болох вэ?

Чуулганы болон гэр бүлийн бүх гишүүд нь ижил үнэ цэнтэй боловч бүгд адил хэмжээний эрх мэдэл, байр суурьтай байдаггүй.

(5) Гурвалд итгэгчдийн хувьд бид хэнд хандан залбирах ёстой вэ?

- Сүнс дотор, Хүүгээр дамжин, Эцэгт
- Эцэгт, Хүүд, Ариун Сүнсэнд хандан

(6) Гурвалын талаарх нийтлэг гурван буруу онол сургаалыг нэрлэнэ үү?

- Бурхан бол өөр өөр үүрэг гүйцэтгэдэг үнэхээр нэг бодгаль юм.
- Эцэг, Хүү, Ариун Сүнс нь салангид тусдаа оршихуй юм.
- Гурвалын нэг нь нөгөөгөөсөө доогуур зэрэглэлд байдаг.

4-р хичээл

Хүн төрөлхтөн

(1) Эхлэл 1:26-27-д хэлсний дагуу хүмүүс бусад бүтээлээс ямар байдлаараа өвөрмөц ялгаатай вэ?

Тэд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн.

(2) Хүмүүний доторх Бурханы дүр төрх нь бие махбодтой төстэй биш гэдгийг мэдэж болох гурван шалтгааныг нэрлэнэ үү?

- Бурхан бол сүнс.
- Бурханы дүр төрхийг хүн шиг болгох нь шүтээн шүтэх явдал юм.
- Хүмүүс бие махбодын хувьд газар дэлхий дээр амьдрахаар бүтээгдсэн.

(3) Хүмүүний доторх Бурханы дүр төрхийн бүрэлдэхүүн хэсгээс долоог жагсаана уу (аль ч долоог нэрлэж болно).

- Бүтээлч инстинкт
- Сэтгэн бодох чадвар
- Харилцах чадвар
- Нийгмийн мөн чанар
- Ёс суртахууны мэдрэмж
- Сонголт хийх чадвар
- Үхэшгүй мөнх байдал
- Хайрлах чадвар
- Мөргөн хүндэтгэх чадвар

(4) Бурханы дүр төрхөөр биднийг бүтээсэн хоёр зорилго юу вэ?

- Бурхантай харилцаатай байх
- Бурханыг мөргөн хүндлэх

(5) Ямар чадвар ёс суртахууны мэдрэмжээс гардаг вэ?

Ойлгож ухамсарлах чадвар болон зөв буруугийн талаарх үзэл баримтлал

(6) Хүмүүс жинхэнэ сонголт гаргах чадвартай байх нь ямар ач холбогдолтой вэ? (аль нэгийг нэрлэнэ үү)

- Бурханы өмнө хариуцлага хүлээдэг.
- Бид гэмшиж, сайнмэдээнд итгэх сонголт.

5-р хичээл

Нүгэл

(1) Бид нүглийг ойлгох ёстой гурван шалтгааныг жагсаана уу.

- Дэлхий ертөнцийн нөхцөл байдлыг ойлгоно
- Нигүүлсэл ба авралыг ойлгоно
- Ариун байдлыг ойлгоно

(2) Нүгэл Бурханы буруугаас болоогүй гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

Бурханы бүтээл төгс байсан бөгөөд Түүний бүтээсэн бүхэн өө сэвгүй байв.

(3) Дараах нүглүүдийг нэг өгүүлбэрээр тодорхойлно уу: санаатайгаар үйлдэх нүгэл, удамшсан завхрал гажуудал, санамсаргүй алдаа зөрчлүүд

Санаатайгаар үйлдэх нүгэл нь Бурханы мэдүүлсэн хүслийг зориудаар зөрчих явдал юм.

Удамшсан завхрал гажуудал нь хүн төрснөөс эхлээд нүгэлд татагддаг ёс суртахууны мөн чанарын гажуудал юм.

Заримдаа хүн санаандгүй эсвэл мэдэлгүйгээр Бурханы Үгийг санамсаргүйгээр зөрчдөг.

(4) Бид яагаад Бурханы хүслийг ойлгож, үүнийг илүү сайнаар үйлдэх ёстой вэ?

- Бурханыг баярлуулдаггүй зүйлсийг хийхийг бид хүсдэггүй.
- Буруу зүйл хийх нь муу үр дагавартай. Энэ нь санамсаргүй байсан ч мөн адил.
- Бид Христэд итгэгч хүнийхээ хувьд сайн үлгэр дуурайл байх хэрэгтэй.
- Хэрэв бид Бурханы хүслээс зайлсхийхийг оролдвол санаатай үйлдэх нүглийн буруутан болно.

6-р хичээл

Сүнснүүд

(1) Тэнгэрэлч нар ихэвчлэн бие махбодгүй байдгийг бид хэрхэн мэдэх вэ?

Тэнгэрэлч нар сүнснүүд.

(2) Тэнгэрэлч нарыг хэзээ бүтээсэн бэ?

Газар дэлхийг бүтээхээс өмнө, аль нэг цагт.

(3) Тэнгэрэлч нар үхдэг үү?

Тэнгэрэлч нар хэзээ ч үхдэггүй.

(4) Тэнгэрэлч нар бодгаль шинжтэй гэдгийг мэдэх дөрвөн арга замыг нэрлэнэ үү.

- Тэд ярьж, ярилцах чадвартай.
- Тэд Бурханыг мөргөн хүндэтгэдэг.
- Тэд сэтгэл хөдлөлтэй.
- Тэд оюуны чадавхитай.

(5) Библид тэнгэрэлч нарыг нэрлэсэн дөрвөн нэрийг нэрлэнэ үү.

- Херубууд
- Серафууд
- Тэргүүн тэнгэрэлч
- Сүнснүүд

(6) Бурханд үйлчилдэг хүмүүсийн төлөө тэнгэрэлч нар юу хийдэг вэ?

Тэд хүрээлж, хамгаалдаг.

(7) Бузар муу сүнснүүд хаанаас гаралтай вэ?

Тэд Бурханы эсрэг тэрсэлсэн тэнгэрэлч нар юм.

(8) Шүтээн шүтэгч нь яг үнэндээ юуг мөргөн хүндэлдэг вэ?

Чөтгөрүүд / бузар муу сүнснүүдийг

(9) Сатан болон бусад бузар муу сүнснүүдийн эцсийн хувь тавилан юу вэ?

Галт нуур

(10) Итгэгч хүн Сатаны дайралтаас өөрийгөө хамгаалахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

Сүнслэг хуяг дуулгаа өмсөх (Ефес 6:13).

7-р хичээл

Христ

(1) Мессиагийн нэн тэргүүний зорилго юу байсан бэ?

Ард түмнээ нүглээс нь чөлөөлөх

(2) Эртний чуулган “Есүс бол Эзэн” гэж хэлэхдээ ямар санааг илэрхийлдэг байсан бэ?

Тэр бол бүхний Эзэн, орчлон ертөнцийг Бүтээгч ба Бурхан мөн

(3) Есүс ямар байдлаараа Бурханы онцгой Хүү нь вэ?

Тэр Эцэгийн мөн чанарыг бүрэн хуваалцдаг цорын ганц Нэгэн.

(4) Биежилт гэж юу вэ?

Бурхан хүний биеийг авч, хүн болсон.

(5) Есүс хүн гэдгийг мэдэх гурван чухал шалтгааныг жагсаана уу.

- Тэр золиос болж зовж, үхэж чадах байв.
- Түүний зөвт байдал биднийг зөвт болгож, амийг өгч чадна.
- Тэр биднийг Бурханы өмнө төлөөлөх тахилч байж чадна.

(6) Есүс Бурхан гэдгийг мэдэх гурван чухал шалтгааныг жагсаана уу.

- Түүний золиос бүхий үхэл нь хязгааргүй үнэ цэнтэй.
- Түүнд биднийг аврах хүч бий.
- Бид Эцэгийг мөргөн хүндэтгэдэг шигээ Түүнийг мөргөн хүндэтгэх ёстой.

(7) Тахил золиос шаардлагатай байсан хоёр шалтгаан юу вэ?

- Бурхан биднийг уучилж, биднийг зөвт, ариун байлгахын тулд
- Хэрэв Тэр нүглийг үндэслэлгүйгээр зүгээр л уучилсан бол энэ нь Бурхан шударга бус, нүгэл тийм ч ноцтой биш гэдгийг илтгэх байсан.

(8) Есүс яагаад өөр аргаар биш, загалмай дээр үхэх болсон бэ?

Тэр Бурханы хараалыг Өөр дээрээ авсан гэдгийг харуулдаг

(9) Есүс биеэр амилсан ач холбогдлын талаарх гурван шалтгааныг жагсаана уу.

- Тэр нүгэл ба үхлийг бүрэн ялсан гэдгийг харуулсан.
- Тэр Өөрийнхөө талаар юу гэж хэлж байсныг баталсан.
- Бид ч мөн үхлээс амилуулагдана гэдгийг баталдаг.

8-р хичээл

Аврал

(1) Хүмүүс яагаад загалмайд дургүйцдэг вэ?

Загалмай нь хүн гэгч уучлал хэрэгтэй нүгэлтэн гэдэг утгыг илэрхийлдэг учраас.

(2) Гэмшээгүй нүгэлтэн бүрийн дөрвөн үнэн байдлыг жагсааж бичнэ үү.

- Нүгэлтэн бүр олон нүгэлт үйлдлийнхээ улмаас гэм буруутай.
- Нүглээ гэмшээгүй хүн Бурханы дайсан юм.
- Нүгэлтэн хүсэл тачаалдаа ялзарсан байдаг.
- Өөрийнхөө нөхцөл байдлыг өөрчлөх хүчгүй.

(3) Эвлэрүүлэлгүй уучлал яагаад Бурханыг үл хүндэтгэсэн хэрэг болох вэ?

Тэгвэл Бурхан шударга биш, бас ариун ч биш гэсэн үг болно.

(4) Есүс тахил золиосын онцгой шаардлагыг ямар хоёр замаар хангасан бэ?

- Тэр ямар ч нүгэлгүй.
- Тэр Бурхан бас хүн байв.

(5) Гэмшсэн нүгэлтэн юуг ухамсарлах ёстой вэ?

- Өөрийнхөө гэм буруутай, шийтгэл хүртвэл зохих байдлыг ухамсарлах.
- Нүглээсээ эргэж буцна.

(6) Авралын итгэлтэй хүн юунд итгэдэг вэ?

- Өөрийгөө зөвтгөх юуг ч хийж чадахгүй.
- Христийн тахил золиос түүнийг уучлахад хангалттай.
- Есүс нүгэл, үхлийг ялан дийлж, үхлээс амилсан.
- Бурхан түүнийг итгэлийнх нь үндсэн дээр л уучилсан.

(7) Аврагдсан гэдгээ хүн яаж баттай мэдэх вэ?

- Үнэхээр гэмшвэл
- Бичвэр дэх Бурханы амлалтад итгэвэл
- Сүнсний гэрчлэлийг хүлээн авсан бол

9-р хичээл

Авралын асуудлууд

(1) 1 Иохан номын гол сэдэв юу вэ?

Хувь хүний авралын баталгаа

(2) 1 Иохан захидалд итгэгч хүний ямар шинжийг хамгийн их онцолсон бэ?

Нүглийг ялан дийлэх

(3) 1 Коринт 10:13-р эшлэлээс бидний мэдсэн дөрвөн зүйл юу вэ?

- Бид хүн учраас сорилт бидэнд тохиолддог.
- Бурхан бидний хязгаарыг мэднэ.
- Бурхан бидэнд учирч буй сорилтыг хязгаарладаг.
- Ялалтад хэрэгтэй зүйлсийг маань Бурхан хангадаг.

(4) Итгэгч хүн яавал Христ дотор байх вэ?

Бурханы тушаалыг сахивал

(5) Бид Христтэй харилцах авралын харилцаагаа хэрхэн хадгалах вэ?

Бурханд итгэж, дуулгавартай дагах замаар хадгалдаг.

10-р хичээл

Ариун Сүнс

(1) Чуулган анх Ариун Сүнсстэй харилцаж байсан гурван загварыг энд нэрлэнэ үү.

- Тэд Ариун Сүнснийг Бурхан хэмээн хүндэлсэн.
- Тэд Ариун Сүнсний оршихуй, удирдамж, үйл ажиллагааны талаар ойлгож байсан.
- Тэд Ариун Сүнснээс хамааралтай байж, Түүнтэй харилцах үүрэг хариуцлагаа ухамсарлаж байсан.

(2) Ариун Сүнсийг бодгаль гэдгийг бид хэрхэн мэдэх вэ?

Ариун Сүнсэнд оюун ухаан, хүсэл зориг, сэтгэл хөдлөл байдаг.

(3) Ариун Сүнсийг Бурхан гэдгийг мэдэж болох таван арга зам юу вэ?

- Тэр бүхнийг мэддэг.
- Тэр хаа сайгүй оршдог.
- Түүнд бүхий л хүч бий.
- Тэр доромжлолыг мэдэрдэг.
- Тэр бол мөнх.

(4) Ариун Сүнсний үйл хэргээс есийг жагсааж бичнэ үү (Аль нь ч байж болно).

- Тэрээр нүглийг буруушаадаг.
- Тэрээр нүгэлд үхсэн хүнд амь өгч, сэргээдэг.
- Тэрээр итгэгчдэд аврагдсан гэдгээ мэдэх хувьчилсан баталгааг өгдөг.
- Тэрээр итгэгч бүрийн дотор оршдог.
- Тэрээр Бурханы үнэнийг ойлгуулдаг.
- Тэрээр хүмүүсийг онцгой үйлчлэлд дуудаж, үйлчлэлийн шийдвэрт дагуулдаг.
- Тэрээр итгэгчийг ариусгаж, түүнийг ариун байлгахын тулд зүрх сэтгэлийг нь цэвэрлэдэг.
- Тэрээр нүглийг ялж амьдрах хүчийг өгдөг.
- Тэрээр итгэгчийн амьдралд сүнслэг үр жимсийг ургуулдаг.
- Тэрээр үйлчлэх билэг авьяас өгдөг.
- Тэрээр үйлчлэх онцгой тосолгоо өгдөг.
- Тэрээр итгэгч хүнд Бурханы хүслийн дагуу залбирахад нь тусалдаг.
- Тэрээр чуулганд эв нэгдэл, нөхөрлөлийг өгдөг.

(5) Бидний амьдрал дахь Ариун Сүнсний нэн тэргүүний зорилго юу вэ?

Нүглийг ялах ялалтыг өгч, цэвэр ариун зүрх сэтгэлтэй болгох.

11-р хичээл

Христитгэлийн ариун байдал

(1) Ариун гэх нэр томъёоны утга юу вэ?

Тусгаарлах, ямар нэг зорилгод зориулагдсан гэсэн утгатай.

(2) Бурханы хувьд ариун байдал гэж ямар утгатай вэ?

Ариун гэдэг нь Бурхан Өөрөө бүхий л нүгэлтэй, цэвэр бус, нийтлэг, жирийн эсвэл Түүний тэнгэрлэг мөн чанар, байр сууринд үл нийцэх юмсаас бүрэн тусгаар гэсэн утгатай.

(3) Мөргөн хүндэтгэхэд ариун байдал яагаад чухал вэ?

- Бид Бурханыг хайрладаг ба Түүнтэй адил байхыг хүсдэг.
- Бид Бурханыг хайрладаг ба Түүнийг баярлуулахыг хүсдэг.

(4) Христитгэлийн ариун байдал хэзээ эхэлдэг вэ?

Хүн аврал авах үеэс

(5) Гэрэлд алхах гэж ямар утгатай вэ?

Бурханы үнэний талаар илүү ихийг мэдэхийн хэрээр Бурханыг үргэлжлүүлэн дуулгавартай дагахыг хэлнэ.

(6) Насан туршийн ариусгалын үйл явцын дунд итгэгч хүн ямар болдог вэ?

Нүгэл болон ертөнцийн хүслээс улам бүр салж, Бурханд өөрийгөө зориулдаг.

(7) Удамшсан завхрал гажуудал гэж юу вэ?

Хүн төрснөөс эхлээд нүгэлд татагддаг ёс суртахууны мөн чанарын гажуудал юм.

(8) Итгэгч хүн яаж Эзэнийг ирэх хүртэл бие, сэтгэл, сүнсээрээ гэм зэмгүй байх вэ?

Ариусгал дундуур явсаар байх

12-р хичээл

Чуулган

(1) Чуулганы эрин үе хэзээ эхэлсэн бэ?

Пэнтекостын өдрөөс чуулганы эрин үе эхэлсэн.

(2) Чуулганыг яагаад элчийн гэж нэрлэдэг вэ?

Элч нарын сургаал нь чуулганы үндсэн сургаал учраас.

(3) Чуулганы үүссэн 4 шалтгаан юу вэ?

- Есүсийн үйлчлэл
- Христийн өгсөн аврал
- Пэнтекостын өдөр болсон үйл явдал
- Элч нарын сургаалын хөгжил

(4) Даяар чуулган гэж юу вэ?

Бүх цаг үеийн, бүх газар нутгийн бүх итгэгчдээс бүрдэнэ.

(5) Нутгийн чуулган гэж юу вэ?

Христийн биеийн төлөө хамтдаа үйлчилдэг, нэг газарт байгаа итгэгчдийн нэгдэл.

(6) *Католик чуулган* гэдэг нь анх ямар утгатай байсан бэ?

Бүх жинхэнэ итгэгчдийг багтаасан даяар чуулган.

(7) Даяар чуулган ямар хоёр зүйлээрээ нэгдмэл вэ?

- Элч нарын онол сургаал
- Хувьсган өөрчилдөг Христтэй харилцах харилцаа

(8) Чуулганууд онол сургаалынхаа талаар бичгээр тунхаглал гаргах нь яагаад зүйтэй вэ?

Энэ нь ойр дотно нөхөрлөж, байнга мөргөл хүндэтгэл, үйлчлэл хийдэг хэсэг бүлэг итгэгчдийг ямар онол сургаал нэгтгэж байгааг харуулахад тустай.

(9) Нутгийн чуулганы зорилгуудаас зургааг жагсааж бичнэ үү (Аль ч зургаа байж болно).

- Сайнмэдээ тараах
- Чуулганаараа мөргөл хүндэтгэл өргөх
- Сургаалаа сахих
- Пасторыг санхүүгээр дэмжих
- Илгээлтийн эздийг дэмжих, илгээх
- Тусламж хэрэгтэй гишүүдэд туслах
- Нүгэлд унасан итгэгчдийг сахилгажуулах
- Баптисм, Эзэний зоогийн ёслолыг үйлдэх
- Дагалдагчдыг төлөвшилд сургах
- Орон нутгийнхаа хэрэгцээнд үйлчлэх

13-р хичээл

Мөнхийн хувь тавилан

(1) Тэнгэрийн улсын үндсэн үйл хэрэг юу вэ?

Мөргөл хүндэтгэл

(2) Тэнгэрийн улсад байхгүй дөрвөн зүйлийг нэрлэнэ үү (аль ч дөрөв байж болно).

- нүгэл
- өвчин
- шаналал
- тэмцэл
- аюул
- өвчлөл
- хөгшрөл
- үхэл

(3) Тэнгэрийн улсыг хэнд зориулж бэлтгэсэн бэ?

Нүглээ гэмшиж, Есүс Христийг Аврагч, Эзэн гэж итгэдэг хүмүүст.

(4) Хүн хэзээ тэнгэрт очдог вэ?

Нас барах үедээ, эсвэл Есүсийг эргэн ирэх үед.

(5) Гараа тасд гэж хэлсэн Есүсийн үг ямар утгатай вэ? (Матай 5:30).

Нүгэлд унагаж, тамд хүргэж чадах үйлдлийг зогсоо.

(6) Тамын талаар Библид дурдсан гурван зүйл?

- Мөнхийн
- Буцах замгүй
- Зовлонтой

(7) Там мөнх байдаг гурван шалтгааныг нэрлэнэ үү.

1. Нүгэл бол хязгааргүй Бурханы эсрэг тэрслэл.
2. Гэмшээгүй нүгэлтнүүд Бурханд мөнхөд үйлчлэх өртэй гэдгээ үгүйсгэдэг.
3. Бид мөнхийн бүтээл учраас хэрэв Бурханаас салахыг сонговол бидэнд өөр очих газар байхгүй.

14-р хичээл

Эцсийн үйл явдал

(1) Библийн эш үзүүллэгийн дагуу, эцсийн үйл явдлын тухай дөрвөн үнэн юу вэ?

- Есүс биеэрээ эргэж ирнэ
- Бүх хүний биеийн амилал
- Шүүлт
- Бурханы мөнхийн хаанчлал

(2) Есүсийг эргэн ирэхэд юу юу тохиолдох вэ?

- Нас барсан итгэгчид амилна.
- Бүх итгэгчид Эзэнтэй уулзахаар дээш өргөгдөнө.

(3) Есүсийн эргэн ирэхийг бид хэрхэн хүлээх вэ?

- Мөнхийн үнэ цэнтэй зүйлсээ хадгалж,
- Цэвэр ариун амьдарч,
- Залбирч, өөрсдийгөө сүнслэгээр хамгаалж хүлээдэг.

(4) Амиллын талаарх онол сургаал яагаад үнэ цэнтэй вэ?

- Есүс үхлээс амилсан.
- Бүх хүнийг амилуулна.
- Бие махбод мөнхийн үнэ цэнтэй.
- Сайнмэдээ үнэн юм.

(5) Шүүлтийн талаар бидний мэдэх ёстой дөрвөн зүйл юу вэ?

- Нүглийн үр дагавар
- Бурханы өмнө хүлээх бидний хариуцлага
- Бидний сонголтын ач холбогдол
- Бүх нүгэл төгсгөлтэй

15-р хичээл

Эртний тунхгууд

(1) Тунхаг гэж юу вэ?

Христэд итгэл үнэмшлийн хураангуй юм.

(2) Есүсийн талаарх анхны хоёр тунхаглалыг нэрлэнэ үү.

- Есүс бол Эзэн
- Эзэн Есүс Христ

(3) Хэд хэдэн тунхаглал агуулсан, хамгийн эртний тунхаг Библийн аль хэсэгт байдаг вэ?

1 Тимот 3:16

(4) Элч нарын итгэлийн тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

Элч нарын онол сургаалыг тодорхой илэрхийлэх.

(5) Никайн тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

Христийн Бурхан мөн чанар болон Ариун Сүнсний тухай онол сургаалыг хамгаалах.

(6) Калседоны тунхаг ямар зорилгоор бичигдсэн бэ?

Христийн биежилтийн талаарх онол сургаалыг хамгаалах.